



I-III/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 14



## Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улиралд 0.6 хувиар өслөө.

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 491.4 тэрбум төгрөгт болж, 487.0 (99.1%) тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 4.4 (0.9%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 1. Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар


	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021* I-III	2021* I-III 2020 I-III	
					дүн	хувь
	тэрбум төгрөг					
<b>Нийт</b>	<b>346.8</b>	<b>426.6</b>	<b>488.3</b>	<b>491.4</b>	<b>3.1</b>	<b>100.6</b>
Дотоодын байгууллага	272.0	416.2	482.2	487.0	4.8	101.0
Төрийн	1.6	1.5	3.4	76.4	72.9	22.2 <sup>1</sup>
Хувийн	269.4	412.1	477.6	400.8	-76.8	83.9
Гадаадтай хамтарсан	1.0	2.6	1.1	9.9	8.7	8.8 <sup>1</sup>
Гадаадын байгууллага	74.8	10.4	6.1	4.4	-1.7	72.6

<sup>1</sup> - Дахин их

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3.1 (0.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 1.7 (27.4%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч дотоодын барилгын байгууллагынх 4.8 (1.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

Дотоодын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 400.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 76.8 (16.1%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 76.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 72.9 (22.2 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 9.9 тэрбум төгрөгт хүрч 8.7 (8.8 дахин) тэрбум төгрөгөөр түс түс өссөн байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, ТӨРЛӨӨР, ТЭРБУМ ТӨГРӨГ




Энэ оны эхний улирлын байдлаар барилга угсралт, их засварын ажлын 28.6 хувийг орон сууцны барилга, 48.9 хувийг орон сууцны бус барилга, 20.6 хувийг инженерийн барилга, байгууламж, 1.9 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс их засварын ажлын эзлэх хувь 1.1 пунктээр, инженерийн барилга, байгууламжийнх 14.4 пунктээр тус тус өссөн бол орон сууцны барилгын эзлэх хувь 2.2 пунктээр, орон сууцны бус барилгынх 13.3 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ УЛИРЛЫН БАЙДЛААР

	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021* I-III	2021* I-III 2020 I-III	
	тэрбум төгрөг				дүн	хувь
<b>Орон сууцны бус барилга</b>	<b>202.8</b>	<b>288.6</b>	<b>303.8</b>	<b>240.5</b>	<b>-63.2</b>	<b>79.2</b>
Үйлдвэрийн	152.1	201.3	133.2	167.3	34.1	125.6
Худалдаа, үйлчилгээний	19.2	13.2	12.2	7.7	-4.5	63.4
Эмнэлгийн	6.0	15.2	9.1	6.2	-2.9	67.9
Сургууль, соёлын	11.2	37.6	53.7	36.9	-16.7	68.8
Бусад	14.4	21.3	95.6	22.4	-73.2	23.4

Орон сууцны бус барилгын гүйцэтгэл 2021 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 240.5 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 63.2 (20.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд үйлдвэрийн барилгын гүйцэтгэл 34.1 (25.6%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч худалдаа, үйлчилгээний барилгынх 4.5 (36.6%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 2.9 (32.1%) тэрбум төгрөгөөр, сургууль, соёлын барилгынх 16.7 (31.2%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 73.2 (76.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

## ЗУРАГ 2. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөг



Улаанбаатар хотод 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 187.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 38.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр буурсан байна. Харин барилга угсралт, их засварын ажлын 61.5 хувийг аймаг, орон нутагт баригдаж буй барилга угсралт, их засварын ажил эзэлж байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 172.7 тэрбум төгрөг, Дорноговь аймагт 79.0 тэрбум төгрөг болсон бөгөөд тус аймгуудын нутаг дэвсгэрт төмөр замын барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.

### Ойлголт, тодорхойлолт

- Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.
- Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.
- Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.
- Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.

**Тайлбар:** ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

**Эх үүсвэр:** ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархах хуваарь:** 2021 оны 8 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас: (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Д.Баасан  
Утас: (976-510)-261502

